



ТӨВ АЙМАГ
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/84

Бүрэн сум

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах
"Иргэн-эрхэм хэрэглэгч" сарын аян
зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрэглэгчдийн эрхийг хамгаалахтай холбогдуулан худалдаа үйлчилгээний газруудын үйлчилгээний чанар, Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, байгууллагуудын хоол хүнсний чанарыг сайжруулах зорилгоор "Иргэн-эрхэм хэрэглэгч" сарын аяныг 2023 оны 04-дүгээр сарын 25-наас 2023 оны 05-дугаар сарын 24-ний өдрийг дуустал зохион байгуулсугай.

2.Иргэн-Эрхэм хэрэглэгч сарын аяныг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдгээр хавсралтаар баталсугай.

3.Сарын аянд хийгдэх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

4.Аяны хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнд сумын худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг бүрэн хамруулж, төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг чанартай хийж гүйцэтгэн үр дүнг олон нийтэд мэдээлж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Пүрэв-Очир)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.ТҮВШИНБАТ

412305192

Сумын Засаг даргын 2023 оны... дүгээр сарын...-ны
өдрийн... дугаар захирамжийн нэгдүгээр хавиралт



Ажлын хэсгийн ахлагч:

Б.Отгонхишигт

(Засаг даргын Тамгын газрын дарга албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Ц.Лхагва

(1-р багийн Засаг дарга)

Б.Азжаргал

(Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

Б.Сайнбаяр

(Цэцэрлэгийн эрхлэгч)

Д.Мөнхзул

(Эрүүл мэндийн төвийн дарга)

Т.Мөнхбат

(Хэсгийн төлөөлөгч)

Д.Дашлхагва

(Иргэдийн төлөөлөгчийн хурлын төлөөлөгч)

Б.Даваасүрэн

(Иргэдийн төлөөлөгчийн хурлын төлөөлөгч)

Ж.Сосорбурам

(Иргэдийн төлөөлөгчийн хурлын төлөөлөгч)

Ж.Түмэнжаргал

(Иргэдийн төлөөлөгчийн хурлын төлөөлөгч)

Н.Хүрэлбаатар

(Мал эмнэлэгийн мэргэжилтэн)

П.Анхцэцэг

(Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Н.Түвшинжаргал

(Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал
хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч)

-----oOo-----

Сумын Засаг даргын 2023 оны... дүгээр сарын...-ны
өдрийн.../84... дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



**“ИРГЭН - ЭРХЭМ ХЭРЭГЯЭГЧ” САРЫН АЯНЫ ХҮРЭЭНД АВЧ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үйл ажиллагаа	Зорилтот түвшин	Хурэх түвшин	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хугацаа
1	ЕБСургууль, Цэцэрлэгийн хоол, үдийн цайны үйл ажиллагаанд шалгалт хийнэ.	Үдийн цай, хоолны илчлэг чанар байдлыг дээшлүүлэх.	Хүүхдийн хоолоор дамжуулан авах илчлэг, чанар сайжирна.	ЕБСургууль	2023-05-01- 2023-05-22
2	Суманд үйл ажиллагаа явуулж байгаа нийт хүнсний дэлгүүрүүдийн бараанд хориглосон бараа бүтээгдэхүүн борлуулж байгаа тухай хяналт хийж, и баримт олголтыг хэвшүүлнэ.	Хугацаа хэтэрсэн бараа бүтээгдэхүүнийг устгалд оруулах.	Сумын худалдаалагдаж байгаа бараа бүтээгдэхүүний чанар дээшилнэ	Ажлын хэсэг	2023-05-15
3	Цайны газруудын хоол хүнс бэлтгэж байгаа байрны эрүүл ахуйн шаардлага хангасан байдалд хяналт хийнэ. Сургууль орчимд худалдан борлуулахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүнийг илрүүлнэ.	Сургууль, дотуур байрны хүүхдүүд, иргэдэд эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хоол хүнсийг хэрэглэх.	Чанартай бүтээгдэхүүн хэрэглэнэ.	Ажлын хэсэг	2023-05-01- 2023-05-22
4	Өмнөх шалгалтаар илэрсэн айл өрхүүдийн цахилгааны утасны чанаргүй байдалд үүссэн зөрчлүүдийг арилгана.	Айл өрх байгууллагуудын цахилгааны утсыг шалгах.	Галын эрсдлээс урьдчилан сэргийлнэ.	Ажлын хэсэг, цахилгааны механикч	2023-05-20
5	Малчдад ахуйн хүрээний гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж өгнө.	Зөөврийн аккумуляторт тог хязгаарлагчтай байхыг зөвлөнө.	Галын эрсдлээс урьдчилан сэргийлнэ.	Ажлын хэсэг	2023-05-01- 2023-05-22

6	Хүнсний хэрэглээний үнийн мэдээг авч иргэдэд мэдээллийн сүлжээгээр мэдээлэх.	Нарийн бичгийн дарга	2023-05-01- 2023-05-22
7	Хүнсний нөөцийн судалгааг 7 хоног бүр авч програмд шивж оруулах.	Нарийн бичгийн дарга	2023-05-01- 2023-05-22
8	Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа авч, санал хүсэлтийг шийдвэрлэнэ.	Нарийн бичгийн дарга	2023-05-31

-----o0o-----

